

5. “МАХАН БИЕЙН ХҮСЛИЙГ ЮУГААР Ч БҮҮ ХАНГА.”

“Эзэн Есүс Христийг өөртөө өмс. Хүсэл тачаалынх нь талаар махан биеийг юугаар ч бүү ханга” (Ром 13:14).

Үйлс 19:19–20

“Чи тэдний бурхдынх нь сийлмэл хөргүүдийг галд шатаа...Чи тийм жигшүүрт зүйлийг гэр орондоо бүү авчир. Чи бас түүн шиг хараал хүртэх вий...” (Дэд хууль 7:25–26).

6. ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ БАЙГАА БОЛ БУРХАНЫГ БҮХ ЗҮРХЭЭРЭЭ ЭРЭЛХИЙЛЭХ ШААРДЛАГАТАЙ.

“Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно” (Иеремиа 29:13, мөн Шастирын дэд 26:5-ыг үз).









1. _____
Ефес 1:13–14

2. _____
Ефес 5:18–19

3. _____
Лук 4:1–14

4. _____
Лук 4:14, Еврей 5:13–14

Хөгжмийг үнэлж дүгнэх үндсэн зарчим

Бидний бүрэлдэхүүн хэсэг	Хөгжмийн үндсэн хэсэг	Хөгжмийн үндсэн чиглэл	Дарамт / Тайвирал	Тэнцвэр алдагдал бий болох гол нөлөө
СҮНС				
СЭТГЭЛ				
БҮГД МАХБОЛ				

ЗӨВ ХӨГЖМИЙН ГУРВАН ШАЛГУУР

1. _____
1 Иохан 4:1

Иаков 3:9–13

Иаков 3:13–18

2. _____
1 Иохан 4:3

1 Тимот 6:3

САЙН ХӨГЖИМ

- _____
- _____
- _____
- _____

ХОРОН МУУ ХӨГЖИМ

- _____
- _____
- _____
- _____
- _____

3. _____
Матай 7:16–20

- _____
- _____
- _____
- _____
- _____

Рок хөгжмийн хүлээст

орсон хүний шинж

□ Рок хөгжимд донтдог.

Донтох (addict-донтон) гэдэг нь ямарваа нэгэн зүйлд эзэмдүүлж, өөрийгөө түүнд бүрэн зориулах гэсэн утгатай. Энэ нь англи хэлэнд “захирах” (dictate) гэсэн үгтэй ижил үндэстэй Латин үгнээс гаралтай юм. Ямар нэг юманд донтсон хүн нь гадны хүчний нөлөөнд байдаг бөгөөд буруу гэдгийг мэдсэн ч хүсэл сонирхолдоо тэсгэлгүй автагддаг.

Рок хөгжимд автагдагсад үүнийг сонсох нь буруу гэдгийг мэддэг байж болох ч өөрийгөө зогсоож дийлдэггүй. Хүүхдийн байцаагч нэгэн “Рок хөгжим хүнийг кокаинаас илүү хордуулан донтуулдаг” гэжээ.

Рок хөгжимд донтогч нь хар тамхичдын адил хөгжим сонсох дур хүсэлдээ хөтлөгдөн Бурханаас заяагдсан эцэг эх, сүнслэг итгэгч найз нөхөдтэйгөө харилцах харилцаагаа золиосолдог.

Хар тамхичид өөрийнхөө дур хүслийг хангах гэж хүсэж тэмүүлдэгтэй адил рок хөгжимд донтогч орон гэр, өрөө тасалгаа, машин унаандаа хөгжим байрлуулж эсвэл чихэвчээр сонсож хүсэл таашаалаа хангаж явдаг.

Түүний зэргэцээ рок хөгжмийн зан үйлийн цаана буй далдын хүчний сүнсээр амьсгалж, рок дуучдын амьдрал, сүүлийн үеийнх нь дуу, мэдээллээр өөрийгөө хангадаг. Рок хөгжмийн хэмнэл, цохилтыг сонсмогц сэргэн идэвхжих бөгөөд сэтгэлд нь хоногшсон ая дууг дахин давтан дуулдаг.

□ Маргалддаг.

Рок хөгжим нь “Хүнийг шүтэн дээдлэх” шашны нэг шинэ хэлбэр юм. Ямар ч үнээр хамаагүй хүсэл ташаалаа биелүүлэх нь хүний амьдралын гол зорилго гэж энэ шашин сургадаг.

Аливаа шашин нь мөн чанараараа бусад шЗашныг тэвчдэггүй. Рокийн шүтэн бишрэгчид, түүний зан үйлийг дагагчид өөрсдийнх нь үзэл бодлын эсрэг, донтоход нь саад болж болохуйц онол, үзэл санааг тэсвэрлэдэггүй.

Рок хөгжмийн эсрэг үзэл онол нь хэдийгээр Бичээс дээр тулгуурласан, уялдаа холбоотой байсан ч тэд үүнийг үгүйсгэх аргаа олдог. Тэдний түшиглэж буй үзэл бодол, зүйрлэл жишээ нь уялдаа холбоогүй, бие биеэ үгүйсгэсэн байдаг.

Жишээ нь: “Хөгжимд ёс суртахуун гэж байхгүй. Иймээс рок хөгжмийг бузар муу гэж үзэж болохгүй. Гэхдээ хэтэрхий хүнд рок хөгжим буруу. Тийм учраас сонсохгүй” гэдэг.

Хэрвээ хөгжимд ёс суртахуун гэдэг ойлголт үнэхээр байхгүй юм бол тэд сайн ба муу рок хэмээн дураараа ангилах нь утгагүй юм.

Зарим хүн замын хөдөлгөөний дүрмийг дагадаггүйгээс болоод бүгд машинаа тавьж явган явдаггүйтэй адил хэн нэгний дургүйг хүргэхгүйн тулд рок хөгжим сонсохгүй байх нь утгагүй хэмээн уялдаа холбоогүй жишээг ашигладаг.

Энэхүү алдаатай жишээнд машиныг рок хөгжимтэй, явган явахыг рок хөгжмийг сонсохгүй байхтай адилтгаж байна. Үнэн хэрэгтээ бол аюулгүй жолоодох нь зөв хөгжим, хурдаа хэтрүүлэх нь рок хөгжимтэй адил юм.

□ Жинхэнэ чөлөөлөлт хэрэгтэй.

Зөвхөн Бурхан л “рок хөгжимд донтогч”-ийг Сатаны цайзуудын хүлээснээс чөлөөлж чадна.